



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

Төрийн ордон, Жанжин Д. Сүхбаатарын талбай 1,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 70 16, Факс: (976-11) 32 70 16,
Цахим шуудан: stategreathural@parliament.mn,
Цахим хуудас: www.parliament.mn

2026.06.22 № 40

Улсын Их Хурлын 2025 оны 61 дүгээр
тогтоолын хэрэгжилтийн талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас 2025 оны 6 дугаар сарын 27-ны өдөр баталсан “Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 61 дүгээр тогтоолын дараах заалтуудын хэрэгжилтэд хяналт тавих, ямар үр дүнд хүрсэн талаар дараах асуулгыг Танд тавьж байна.

1. Тогтоолын 1 дэх хэсгийн “2/хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27¹.1, 27¹.2 дахь хэсэгт нийцүүлэх зорилгоор судалгаа хийж, холбогдох хуулийн төслийг 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” заалтын хэрэгжилтийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, ажлын одоогийн явц, цаашид энэ заалтын хэрэгжилтийг хангах талаарх төлөвлөлт;

2. Тогтоолын 1 дэх хэсгийн “3/Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний хянан баталгаажуулсан орчуулга, тэдгээрийн эх бичвэрийг эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд 2026 онд багтаан бүрэн эхээр байршуулах” ажлын явцын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, цаашдын арга хэмжээний төлөвлөлтийн талаар;

3. Тогтоолын 1 дэх хэсгийн “4/хууль санаачлагчид мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх үүрэг бүхий төрийн холбогдох байгууллагын албан хаагчдыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан холбогдох аргачлал, арга зүйгээр хангах, чадавхжуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, хэрэгжүүлэх” заалтын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаарх мэдээлэл;

4. Тогтоолын 2 дахь хэсгийн “1/хуулиар тусгайлан эрх олгогдоогүй бөгөөд нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр баталсан дүрэм, журам, заавар, аргачлалыг хүчингүй болгох” ажлын явц, үр дүнгийн талаарх дүгнэлт, мэдээлэл;

5. Тогтоолын 2 дахь хэсгийн “2/хуульд заасны дагуу баталсан боловч бүртгүүлээгүй захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх” заалтын хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаарх мэдээлэл;

6.Тогтоолын 2 дахь хэсгийн “3/эрх зүйн зохицуулалтын ач холбогдлоо алдаж дагаж мөрдөхгүй болсон, хууль тогтоомжтой зөрчилдсөн, эрх олгосон хуулийн заалт нь хүчингүй болсон, өөрчлөгдсөн захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох, хуульд нийцүүлэн шинэчлэн батлах” чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаарх мэдээлэл;

7.Тогтоолын 2 дахь хэсгийн “4/эрхлэх асуудлын хүрээнд хамаарах захиргааны хэм хэмжээний актын хууль зүйн үндэслэлийг нягтлан шалгаж, хуулиар тогтоосон хязгаарлалтаас гадуур хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, ашиг сонирхлын зөрчил, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн шинжтэй дүрэм, журам, тэдгээрийн холбогдох зохицуулалтыг хүчингүй болгох, өөрчлөх” чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаарх мэдээлэл;

8.Тогтоолын 4 дэх хэсэгт заасан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хуульд нийцүүлэн хийж, үнэлгээг эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд тогтмол байршуулах ажлыг зохион байгуулах” ажлын хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаарх мэдээлэл.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



Х.БААСАНЖАРГАЛ

2026000116